



БУЛГАН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 09 сарын 14 өдөр

Дугаар 116

Булган

Дуудлага худалдаа
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 132 дугаар тогтоол, 2014 оны 17 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгө олж авах, худалдах, шилжүүлэх, актлах журам"-ыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Дуудлага худалдаагаар борлуулах тээврийн хэрэгслэлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.
2. Дуудлага худалдааг 2017 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 11 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд явуулсугай.
3. Дуудлага худалдааны орлогыг 100 хувь аймгийн хөрөнгө борлуулсны орлогын дансанд төвлөрүүлсүгэй.
4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавин, хавсралтад заагдсан тээврийн хэрэгслэлүүдийг аймгийн төвд татан төвлөрүүлж, дуудлага худалдааг зохион байгуулж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Батжаргал/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Handwritten signature

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
хурлын 2017 оны 14 дугаар
Тогтоолын хавсралт



ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ХУДАЛДАН
БОРЛУУЛАХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ

/Төгрөгөөр/

№	Сум, байгуулага	Хөрөнгийн нэр төрөл	Улсын дугаар	Дуудах анхны үнэ
1	Орхон сум ЭМТ	УАЗ-315122	97-98 БУА	1.200.000
2	ГБХЗХГ	Nissan sannu	73-45 БУА	1.500.000
3	ОНӨГ	Суудлын автомашин /Sonata-5 /	71-06 ОРА	350.000
4	Баян-агт сум ЗДТГ	УАЗ-315122	16-38 БУА	700.000
5	Хялганат тосгон ЭМТ	УАЗ-315122	98-41 БУА	1.200.000
	Хөрөнгийн дүн			4.950.000

БУЛГАН АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРАЛ
ХУУЛБАР ҮНЭН
ОГНОО 2017.09.18

-oOo-